



ҮАГазрын харъяа Баян-Өлгий аймаг дахь Аудитын газар

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Татварын хэлтсийн  
2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон  
жилийн эцсийн санхүүгийн тайлан

**Аудитын код: БӨА-2017/80/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: bayan\_ulgii@mta.gov.mn

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382      Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710      Цахим хаяг: kh\_jenisbek@yahoo.com

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 89837414      Цахим хаяг: Elbegeeuuree@yahoo.com

## Агуулга

|       |                                                                                                               |                                     |
|-------|---------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|
| 1     | Аудитын гэрчилгээ .....                                                                                       | 2                                   |
| 2     | Аудитын тайлан .....                                                                                          | 4                                   |
| 2.1   | Оршил .....                                                                                                   | 4                                   |
| 2.2   | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....                                         | 4                                   |
| 2.3   | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....                                        | 5                                   |
| 2.4   | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....                                              | 5                                   |
| 2.5   | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 6                                   |
| 2.6   | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....                                         | 6                                   |
| 2.7   | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....                                                    | 7                                   |
| 2.8   | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....                                                   | 7                                   |
| 2.9   | Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл .....                                       | 8                                   |
| 2.9.1 | Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал .....                                                        | 8                                   |
| 2.9.2 | Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал .....                                                          | 8                                   |
| 2.9.3 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .....                                       | 9                                   |
| 2.9.4 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал .....                                | 9                                   |
| 2.10  | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....                                  | 9                                   |
| 2.11  | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....                                                         | 9                                   |
| 2.12  | Шилэн дансны мэдээлэл .....                                                                                   | 10                                  |
| 2.13  | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....                                                | 10                                  |
| 2.14  | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....                                                                       | 11                                  |
| 3     | Менежментийн захидал .....                                                                                    | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 3.1   | «management_zurchil1» .....                                                                                   | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 3.2   | «management_zurchil2» .....                                                                                   | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 4     | Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                                             | 12                                  |
| 4.1   | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                                                                  | 12                                  |
| 4.2   | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....                                                               | 13                                  |
| 4.3   | Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..                                                       | <b>Error! Bookmark not defined.</b> |
| 4.4   | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....                                                                   | 16                                  |
| 4.5   | Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                                                                | 18                                  |

## 1 Аудитын гэрчилгээ

Баталгаажуулсан гэрчилгээг сканнердаж оруулах



ТАТВАРЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА Т.ФЕСТИВАЛЬ ТАНАА

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 70422954, 70422930  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2017.04.10 № 07/2017-001/10/17-7012  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Аймгийн Татварын хэлтсийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу Үндэсний аудитын газрын харьяа Баян-Өлгий аймгийн аудитын газраас аудит хийв.

Төсвийн захирагч нь тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Татварын хэлтсийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулга материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Sanal Sh.doc

### Зөрчилгүй санал дүгнэлт

Татварын хэлтсийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.ХУАНГАН

## **2 Аудитын тайлан**

### **2.1 Оршил**

Татварын хэлтсийн дарга Т.Фестиваль танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналттай холбоотой Менежментийн захидалд өгөгдөөгүй болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Татварын хэлтсийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Татварын хэлтсийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017.01.30-наас 2017.02.10-ны хооронд хийж, аудитын тайланг 2017.02.10-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аудитын газрын аудитор Б.Үүрийнтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Татварын хэлтсийн 2016 он оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017.01.19 - нд төрийн аудитын байгууллагад 2016.01.16-ны өдрийн №13–р албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Татварын хэлтэс *“Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, татвар төлөгчдөд сургалт, сурталчилгаа явуулах, зөвлөгөө өгөх” эрхэм зорилгын дор* Татварын Ерөнхий газрын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Татварын хэлтэс дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Татварын хэлтэс *“Татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулах, шинэчлэгдсэн хуулийн хэрэгжилтийг хангах” зорилт* дэвшүүлэн ажиллажээ.

Татварын хэлтсийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Татварын хэлтсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2016 оноос НӨАТатварын тухай хуулийн шинэчлэлтээр НӨАТ-ын урамшуулалын системийг шинээр нэвтрүүлж, буцаан олголт өгч эхэлсэн байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Татварын хэлтсийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Тус хэлтэст 2016 оны 6-р сард ТЕГазраас “Шалган зааварчлах групп”-ын баг ирж дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Татварын хэлтсийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Татварын хэлтэс санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Emerald” програм хангамж ашиглажээ. Дээрх программыг 2015 оноос үр дүнтэй ашиглаж байна.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Татварын хэлтсийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 6 асуудал эрсдэл өндөр, 0 асуудал эрсдэл дунд, 0 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 18 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 6 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих - шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгож төлөвлөсөнтэй холбоотой юм.

Татварын хэлтсийн 2016 он оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 537,4 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 10,7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь төлөвлөлтийн шатанд 2 хувиар тооцсонтой холбоотой юм.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 12 эрсдэлтэй асуудалд 12 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 8.3 хувь буюу 1 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

|     |                                                      |     |     | (Сая төгрөгөөр) |
|-----|------------------------------------------------------|-----|-----|-----------------|
| №   | Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал | Тоо | Дүн | Тайлбар         |
| 1   | Зөвлөмж болгосон асуудал                             | 0   | 0   |                 |
| 2   | Төлбөрийн акт тогтоосон                              | 1   | 0,4 |                 |
| 3   | Албан шаардлага өгсөн                                | 0   | 0   |                 |
| 4   | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн             | 0   | 0   |                 |
| 5   | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн      | 0   | 0   |                 |
| Дүн |                                                      | 1   | 0,4 |                 |

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудал гараагүй байна.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

### 2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Ажиллагсадад олгосон цалингийн урьдчилгааны тооцоог шалгаж үзэхэд Дэлүүн сумын татварын байцаагчид олгосон цалингийн урьдчилгаанаас 400,0 мянган төгрөгийн урьдчилгааг суутгаагүй, санхүүгийн тайланд авлагаар харуулаагүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төсвийн тухай хуулийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д заасан “Аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах, акт тавих, албан шаардлага өгөх....” гэсэн заалтыг үндэслэн 400,0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

### 2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгөх асуудал гараагүй байна.

**2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар сахилгын шийтгэл ногдуулахаар алдаа зөрчилтэй асуудал гараагүй байна.

**2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал гараагүй байна.

**2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар анхаарал хандуулах болон анхаарал татахуйц бусад асуудал байхгүй байна.

**2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

**Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Татварын ерөнхий газраас Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Татварын хэлтсийн төсвийн захирагч нь 2016 онд 503,9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр урсгал зардалд 503,9 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдэж батлагдсан төсөвтөө багтаан зарлага гаргажээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

| №   | Үзүүлэлт                                   | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|-----|--------------------------------------------|------------|-----------|------|-------|
| 1   | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн          | 503,9      | 503,9     | 0.0% | 0.0   |
| 1.1 | Урсгал зардал                              | 503,9      | 503,9     | 0.0% | 0.0   |
| 1.2 | Хөрөнгийн зардал                           | 0          | 0         | 0.0% | 0.0   |
| 1.3 | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | 0          | 0         | 0.0% | 0.0   |
| 2   | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр             | 503,9      | 503,9     | 0.0% | 0.0   |

|     |                                              |       |       |      |     |
|-----|----------------------------------------------|-------|-------|------|-----|
| 2.1 | Улсын төсвөөс санхүүжих                      | 503,9 | 503,9 | 0.0% | 0,0 |
| 2.2 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 0     | 0     | 0.0% | 0,0 |
| 2.3 | Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос | 0     | 0     | 0.0% | 0,0 |

Тайлант оны батлагдсан төсвийг бүрэн зарцуулж, төсөвт зардлын гүйцэтгэл 100,0 хувьтай гарсан байна.

Урсгал зардлуудаас гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, тээвэр шатахуун, хичээл үйлдвэрлэл дадлагын зардлуудыг 0,05-0,2 сая төгрөгөөр хэтрүүлж, түлш халаалт, шуудан холбоо, бичиг хэрэг, Төрийн нэрийн өмнөөс гүйцэтгсэн ажил үйлчилгээний зардлуудын хэмнэлтээс гүйлгэн зарцуулжээ. Оны эцэст 0,01 мянган төгрөгийн үлдсэн хэмнэлтийг төсөвт төвлөрүүлжээ.

Нийт төсвийн 89,7 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 10,3 хувийг бараа үйлчилгээний бусад зардлууд эзэлж байна.

Тайлант хугацаанд өөрийн орлогын төлөвлөгөө өгөгддөггүй байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 10,7 төгрөг зарцуулсны дотор цалин, нийгмийн даатгалын шимтгэл, бусад урсгал зардалд зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

## 2.12 Шилэн дансны мэдээлэл

Татварын хэлтэс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 12 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 12 горим сорил хэрэгжүүлэв.

## 2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Татварын хэлтэс 2016.10.05-ны өдрийн №475 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

## **2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Татварын хэлтсийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Татварын хэлтсийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

#### 3.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт                  | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл       |
|------------|------------------------------------|-----------------------|-----------------------|
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>     | <b>8,864,830.80</b>   | <b>10,798,876.55</b>  |
| <b>31</b>  | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>              | -                     | -                     |
| <b>311</b> | <b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>  | -                     | -                     |
| 31110      | Төгрөг                             |                       |                       |
| 31140      | Касс арилжааны банк                |                       |                       |
| <b>312</b> | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>  | -                     | -                     |
| <b>33</b>  | <b>АВЛАГА</b>                      | 656,835.00            | 490,972.00            |
| 33100      | Ажиллагчидтай холбогдсон авлага    |                       |                       |
| 33200      | Төлбөртэй үйлчилгээний авлага      |                       |                       |
| 33300      | Татаас, санхүүжилтийн авлага       |                       |                       |
| 33400      | Зээлийн хүүгийн авлага             |                       |                       |
| 33401      | Дансны авлага /ТӨҮГ/               |                       |                       |
| 33402      | Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/    |                       |                       |
| <b>335</b> | <b>Бусад авлага</b>                | 656,835.00            | 490,972.00            |
| 3351       | Байгууллагаас авах авлага          | 605,635.00            | 490,972.00            |
| 3352       | Хувь хүмүүсээс авах авлага         | 51,200.00             |                       |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>              | 8,207,995.80          | 10,307,904.55         |
| <b>351</b> | <b>Түүхий эд материал</b>          | -                     | -                     |
| 35110      | Тусгай зориулалттай материал       |                       |                       |
| 35130      | Эм боох материал                   |                       |                       |
| 35200      | Дуусаагүй үйлдвэрлэл               |                       |                       |
| 35300      | Бэлэн бүтээгдэхүүн                 |                       |                       |
| <b>354</b> | <b>Хангамжийн материал</b>         | 8,207,995.80          | 10,307,904.55         |
| 35410      | Бичиг хэргийн материал             | 2,437,024.80          | 1,792,040.95          |
| 35420      | Аж ахуйн материал                  | 5,770,971.00          | 8,014,771.00          |
| 35430      | Сэлбэг хэрэгсэл                    |                       |                       |
| 35440      | Түлш, шатах тослох материал        |                       |                       |
| 35450      | Барилгын засварын материал         |                       |                       |
| 35460      | Хүнсний материал                   |                       |                       |
| 35470      | Бусад хангамжийн материал          |                       | 501,092.60            |
| 35500      | Биологийн хөрөнгө                  |                       |                       |
| 35600      | Мал амьтад                         |                       |                       |
| <b>36</b>  | <b>НӨӨЦИЙН БАРАА</b>               | -                     | -                     |
| 36100      | Барааны нөөц                       |                       |                       |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b> | <b>240,032,542.60</b> | <b>232,192,070.89</b> |
| <b>39</b>  | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>              | 240,032,542.60        | 232,192,070.89        |
| 391        | Газар                              |                       |                       |
| <b>392</b> | <b>Биет хөрөнгө</b>                | 240,032,542.60        | 232,192,070.89        |
| 39201      | Барилга, байгууламж, орон сууц     | 197,960,194.00        | 197,960,194.00        |
| 39202      | Хуримтлагдсан элэгдэл              | (35,423,607.65)       | (39,178,577.33)       |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл             | 64,372,000.00         | 64,372,000.00         |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл              | (43,920,611.02)       | (51,855,344.62)       |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)  | 83,020,464.50         | 91,354,532.50         |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл              | (44,403,556.39)       | (44,318,393.61)       |

|             |                                                                       |                       |                       |
|-------------|-----------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил                                           | 33,799,861.01         | 30,224,330.96         |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (18,717,811.90)       | (18,086,101.46)       |
| 39213       | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс                                      |                       |                       |
| 39214       | Бусад үндсэн хөрөнгө                                                  | 11,871,303.00         | 9,576,393.00          |
| 39215       | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (8,525,692.95)        | (7,856,962.55)        |
| 39216       | Дуусаагүй барилга, байгууламж                                         |                       |                       |
| 39217       | Ном                                                                   |                       |                       |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>                                               | -                     | -                     |
| 39301       | Програм хангамж                                                       | 830,550.00            |                       |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл                                                 | (830,550.00)          |                       |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>248,897,373.40</b> | <b>242,990,947.44</b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                                                 | <b>1,347,916.00</b>   | -                     |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | 1,347,916.00          | -                     |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>                                                          | 1,347,916.00          | -                     |
| 41310       | Ажилчидтай холбогдсон өглөг                                           |                       |                       |
| 41320       | Бараа үйлчилгээний зардлын өглөг                                      |                       |                       |
| 41350       | Зээлийн хүүгийн өглөг                                                 |                       |                       |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>                                                    | 1,347,916.00          | -                     |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг                                              | 1,347,916.00          |                       |
| 41362       | Хувь хүмүүст төлөх өглөг                                              |                       |                       |
| 41363       | Татварын өглөг /ТӨҮГ/                                                 |                       |                       |
| 41364       | НДШ - ийн өглөг /ТӨҮГ/                                                |                       |                       |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>247,549,457.40</b> | <b>242,990,947.44</b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 247,549,457.40        | 242,990,947.44        |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 263,832,187.20        | 263,832,187.20        |
| 51101       | Өмч: - төрийн                                                         | 263,832,187.20        | 263,832,187.20        |
| 51102       | - хувийн                                                              |                       |                       |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                                           | (94,954,519.80)       | (99,513,029.76)       |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн                                                    | (71,567,027.49)       | (94,954,519.80)       |
| 51220       | Тайлант үеийн үр дүн                                                  | (23,387,492.31)       | (4,558,509.96)        |
| 51300       | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 78,671,790.00         | 78,671,790.00         |
| <b>6</b>    | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>248,897,373.40</b> | <b>242,990,947.44</b> |

### 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт                                                                                                    | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|-------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                                                                      | <b>547,391,216.00</b> | <b>532,805,823.00</b> |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                                                        | <b>547,391,216.00</b> | <b>532,408,323.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                                                              | 525,373,600.00        | 503,962,000.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                                                           | 525,373,600.00        | 503,962,000.00        |
| 131002      | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт                                                      |                       |                       |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                          | 6,643,000.00          | 17,085,000.00         |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 6,643,000.00          | 17,085,000.00         |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                                                                       | 6,883,008.00          | 10,694,623.00         |

|             |                                                                      |                       |                       |
|-------------|----------------------------------------------------------------------|-----------------------|-----------------------|
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/  | 6,883,008.00          | 10,694,623.00         |
| <b>1330</b> | <b>Төсвийн захирагчдаас</b>                                          | 7,516,633.00          | 666,700.00            |
| 133001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                    |                       |                       |
| 133002      | Төвлөрүүлэх шилжүүлэг                                                |                       |                       |
| 133003      | Хөрөнгийн                                                            | 7,516,633.00          | 666,700.00            |
| <b>1340</b> | <b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>                  | 974,975.00            | -                     |
| 134001      | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих                                 | 974,975.00            |                       |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>                                   | <b>570,585,374.78</b> | <b>535,018,393.63</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                                 | <b>570,585,374.78</b> | <b>535,018,393.63</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                               | 562,486,478.78        | 534,620,893.63        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                             | 428,790,578.00        | 414,118,342.00        |
| 210101      | Үндсэн цалин                                                         | 366,371,100.00        | 391,893,242.00        |
| 210102      | Нэмэгдэл                                                             | 6,883,008.00          |                       |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт                                                | 13,346,000.00         | 13,346,000.00         |
| 210104      | Урамшуулал                                                           | 42,190,470.00         | 8,879,100.00          |
